## Залуу эхчүүдэд зөвлөлгөө

# Хөхөө зөв арчилъя

Амьдрал ахуйгаас ажиглахад ялангуяа залуу эхчүүд хөхөө зөв арчлахгүй гэвс болж, хөх сүүгүй боллоо гэж хүүхдээ эрт хөхнөөс гаргах буюу зарим эхчүүд хүүхдийг гарсан цагаас нь хөхүүлэхгүй тэжээвэр байдалд өсгөхийг эрмэлзэж сүүлдээ өөрийн биед болон үр хүүхэддээ нөхөж баршгүй хохирол учруулахад хүрэх тал байх юм.

Энэ нь хөхний булчирхайн үйл ажиллагааны талаар дутуу дулимаг ойлгоцтойгоос болж байна. Иймд эх хүн бүхний мэдэж байвал зохих зарим нэг зүйлээс тодруулбал:

**Хөхний сүү багасах**

Сэтгэл санааны хэт цочрол (доройтол) нь хөхний сүү багасах буюу бүрэн үгүй болгоход нөлөөлнө.

Сэтгэл санааны хөдөлгөөнөөс болоод зарим эмэгтэйчүүдийн хөхөнд жирэмсэн болоогүй ч гэсэн сүү орох явдал байдаг нь дээрх тайлбарын үнэн болохыг үзүүлж байна. Хөхний сүү багадалт нь янз бүр байдаг.

**Анхдагч хэлбэрийн сүү багадалт.** Энэ нь эхнээсээ аваад сүү муутай буюу сүүгүй байна.

Хоёрдогч хэлбэрийн сүү багадалт нь эхэндээ хөхний сүү хэвийн гарч байснаа сүүлдээ сүү багатай буюу сүүгүй болно.

Энэ нь зөв биш хөхүүлснээс буюу эх хэт ядарсан хүнд өвчинд нэрвэгдсэн зэргээс шалтгаална.

Төрсний дараа хэд хэдэн хоногоор сүү бага байх буюу огт сүүгүй байх тал байдаг тул хөхний сүү багадалт, сүүгүй байхыг тэр болгон зөв танихад бэрхтэй.

Хөхний сүү багадалтаас урьдчилан сэргийлэхийн тулд хөхнийхөө сүүг шавхартал сайн хөхүүлэх, илүүдэл сүүг сааж авах заншлыг хэвшил болгох хэрэгтэй.

Калори ба витамин ихтэй сайн чанарын хоол идэж байхаас гадна тайван унтаж, цэвэр агаарт гарч, сэтгэл санааны хүчтэй цочролууд айх, гайхах гомдох, уйтгарт явдлаас аль болохоор зайлсхийж байвал зохино.

**Хөх язрах.** Хөхүүл эхчүүдийн хөхний толгойн арьсны хучаас эд өнгөц хуурч эмзэглэх явдал олонх эхэд тохиолдох боловч тэр бүр өвчний шинж тэмдэг өгдөггүй. Гэвч зарим эхчүүдийн хөхний толгой язрахдаа өвдөлт үүсгэн хүүхдээ хөхүүлэх аргагүй болдог байна.

Язрал нь өнгөц жижиг байхаас гадна арай гүн буюу бүр гүнзгий шархлаа болж болно. Үүсэх шалтгаан нь хүүхдийг зөв хөхүүлж чадахгүй гараар хөхийг буруу саах, хөхөө зөв арчлаагүй, хэт удаан хөхүүлж үлгүүлэх зэргээс болоод хөхний толгой цэврүүтэн язрах, шархлаа суух хүртэл гэмтэнэ.

Хөхний толгойн язарсан хэсэгт цусархаг буюу идээт тав үүсч болно.

Халдвар нь бохир гар, хувцас, ор дэрний хэрэглэл зэргээс орно. Урьдчилан сэргийлэхдээ хувийн ба цагаан хэрэглэлийн ариун цэврийг сахиж хумсаа авсан байх, өглөө бүр хөхүүл эхчүүд мээм, чээжнийхээ дээд хэсгийг угааж хүүхдээ хөхүүлэх бүрийн өмнө гараа савантай бүлээн усаар 2—3 угаасны дараа 025 хувийн нашатырийн спиртээр норгосон марлаар арчиж байхаас гадна хөхний даруулга хийх хэрэгтэй.

Их эмч Доржготов

# ЭЛДЭВ СОНИН

**Копрон.** Копрон нь зохиомол мяндас бөгөөд түүний хүчлийг анх ямааны сүүнээс гарган авсан бөгөөд Грекээр копрон гэдэг нь «ямаа» гэсэн үг ажээ 1 кг копроноор 80 ширхэг урт оймс нэхэх ба копроноор хийсэн эдлэл нь хөнгөн, уян хатан, бөх, усанд удаанаар байлгахад чанар нь огт мууддаггүй онцлогтой юм.

Копроноор хийсэн эдлэлийг угаасны дараа базах юм уу, индүүдэх шаардлагагүй. Учир нь копрон хатмагцаа үйлдвэрээс гарсан анхныхаа хэлбэрт өөрөө орж чадна.

**Интернациональ дуу.** Интернационалийг анх 1871 оны 6 дугаар сард Парисын коммунд оролцогч, нэрт яруу найрагч Эжен Потье зохиож, Белгийн ажилчин, хөгжмийн зохиолч Пьер Дегейтер 1888 онд ая оруулсан юм.

**Антарктид.** Энэ тив 14 сая хавтгай дөрвөлжин км талбай бүхий 200 метр хүртэл зузаан мөсөөр бүрхэгдсэн байхаас гадна мөсөн доороос уулсын оргилууд дөнгөж цухуйх төдий бөгөөд тэдгээрийн өндөр нь заримдаа 5000 метрт хүрдэг байна.

**Борц.** Хатаасан 214 гр борц 1 кг ястай тэнцэнэ.

Борцыг усанд 40 минут дэвтээх үед 2,4—2,5 дахин өсөх бөгөөд 18 минут чанахад бүрэн болно.

Борцны чанар нь ЗХУ-д Субмимацын аргаар хатаасан махны стандартын шаардлагатай тохирдог юм.

Лабратороор шинжлэхэд борцонд уураг 78 хувь, тослог 11,3 хувь байдаг нь нотлогдсоны дээр 100 г борц 386 их калортай тэнцдэг байна.

**Хүний жин.** Хүний дундаж жин өндрөөсөө 100-г хассантай тэнцэнэ.

Дээрх хэмжээнээс жин хэтрэхийг таргалах гэнэ.

Харин 30 хувь хүртэл жин нэмэгдэхийг 1 дүгээр, 30—50 бол 2 дугаар, 50-аас дээш бол 3 дугаар зэргийн тарга гэнэ.

Харин эмэгтэйчүүдийн тарга эрэгтэйчүүдийнхээс 2 дахин давуу байдаг аж.

**Үзэг.** Үг үсгийг бичих бүхэндээ хүн үзгээ өргөдөг. Энэ нь дунджаар минутад 1 кг, цагт 70 гаруй кг ачаа өргөж байна гэсэн үг.

Ажлын өдөр турш бараг л бүтэн тонн ачаа өргөхөд хүрнэ.

Харин Чехословакт хийж байгаа 10 грамм хүрэхгүй жинтэй үзэг бол дээр дурьдсан ачааг өргөхөөс хүнийг чөлөөлж чадах ажээ.

**Цай.** ЗХУ—д цайны ургамал тарьж эхэлсэн анхны район бол Гүрж юм.

Одоо ЗХУ—д 70000 га руй га газар цай тариалж байна. ЗХУ—ын цайны нэг фабрик сард дунджаар 300 тонн цай хийдэг бөгөөд түүнээс 200 тонны нь манай улсад нийлүүлдэг байна. Цайг тусгайлан хураасан навчаар бэлтгэх ба тэрхүү навчнуудыг 250-300 градус хүртэл халааж машины тусламжтайгаар эвхэж 1 метр зузаан хурааж 12—18 цаг байлгадаг байна.

Манай улсад зориулсан цай хийх фабрик Гүржийн Чаквад байдаг бөгөөд энэ нь өнгөрсөн зууны сүүлчээр бий болсон фабрик юм Тэнд зун 10-20 градус заримдаа 60 градус хүйтрэнэ. Харин өвөлдөө хүйтэн нь гол төлөв 50 градусаас буурдаггүй боловч 80 градус хүрэх удаа цөөнгүй ажээ.

**Тоосго.** Тоосгыг чанарын нь талаар 75, 100, 125, 150, 200 маркийн гэж ангилна.

75-аас дээш маркийн тоосгыг олон давхар барилгад ашиглана. 75 маркийн нэг ширхэг тоосго 14.6 тонн ачааг дааж чадах ба 1 шоо метр өрлөгт 402 тоосго орно.

Ер нь тоосго нь уртаараа 25 см, өргөнөөрөө 12 см, зузаанаараа 6,5 см байх ба хүнд нь 3,5—4 кг байна.

Б. Цэрэндаш

# Ангина өвчин

Ангина өвчин нь хүүхэд багачууд, насанд хүрэгчид, аль ч насны хүнд тохиолддог халдварт өвчин юм.

Миндалин (бүйлсэн булчирхай)-д микроб нэвтрэн орж хэлний угт, залгиур хоолойн амсарт жижгэвтэр дугариг хэлбэртэй үрэвсэл бий болж хэмжээ нь томорч ирнэ.

Хэрэв ангина хүнд хэлбэрээр тусвал хүзүүний тунгалагийн зангилгаа хавдах явдал үзэгддэг.

Ангина саяхан болтол хэсэг газрын өвчин гэсэн ойлголт хэвээр байлаа.

Үнэндээ ч эхлээд хоолой сэрвэгнэж загатнах, миндалин үрэвсэх, юм залгихад хөндүүрлэх зэрэг хэсэгхэн газар мэдэгдэм өөрчлөлт гарна.

Өвчин ихтэй үедээ өвчтөн юм идэх уухаа бэрхшээнэ.

Халуун нэмэгдэн, толгой өвдөж, ууц нуруу булчин үе мөчөөр янгинан өвдөж, халуун ихсэх үедээ дагинан чичирч бие сулрах тэмдэг тодорч ирнэ.

Зарим үед миндалин нь үл мэдэг улайж сөөнгөтөөд түргэн эдгэрэх ба зарим үед хоолой нь зузаан өнгөрөөр хучигдан биеийн байдал доройтон скарлатин, Дифтери өвчинтэй андуурч болохоор ч байдаг.

Хүнд хэлбэрийн үед хоолойд буглаа (нарыв) бий болж 39—40 градус хүртэл халуурч хоолой их эмзэглэж өвдөнө

Уул буглаа нь 4—5 өдрөө өөрөө хагарч болох ба хагарахгүй бол эмчид үзүүлнэ.

Өвчин үүсгэгч микробууд нь амны хөндий, миндалинд байнга оршиж байдаг бөгөөд даарч хөрөх, ядаргаа болох зэргээр бие мах бодийн суларч доройтсон үед микробын хордуулах чанар идэвхжин ангина өвчин үүсгэдэг байна.

Хамраар амьсгалахад гадны агаар хамрын хөндийгөөр өнгөрөхдөө микроб шороо, тоос, химийн элдэв хольцоос чийглэгдэн цэвэршиж бүлээцсэн агаар цааш дамжина.

Хамрын хөндийд ямар нэгэн үрэвсэл бий болох юм уу хамар битүүрч, шууд амаараа амьсгалах явдал тохиолдоно

Энэ үед бичил биет, шороо тоос амьсгалын замын салст бүрхэвч, миндалинд агаарын хамт шууд очно.

Энэ нь ангинаар өвчлөх нэг шалтгаан болно.

Шүд хорхойтсон үед шүдний хөндийд төрөл бүрийн микроб хуралдаж ангина өвчин үүсгэнэ.

Өвчилсөн шүд нь халдварын голомт болдог учир өвчилсөн шүд буйлыг цаг тухайд нь эмчлүүлэх нь ангина өвчнөөс урьдчилан сэргийлэх найдвартай аргын нэг юм.

Ангина өвчин хүндэрч эндокардит, ревматизм, нефрит, артрит, пиелит хааяа сепсис болдог.

Ийм учраас ангина өвчнийг цаг алдалгүй эмчлүүлж, эмчийн заавар зөвлөлгөөг нарийн чанд биелүүлэх шаардлагатай.

Ангина архагшин олон дахиж миндалин үрэвсэл томорч архаг тонзолит болно.

Энэ үед ам эвгүй үнэртэй болох, хоолой загатнаж ханиалгах, юм залгихад хөндүүрлэнэ.

Ийм тохиолдлын үед миндалиныг ариутгасан уусмалаар угаах, рентген туяа ба хэт ягаан цацрагаар төөнөх зэргээр дэс дараалсан эмчилгээ хийж үр дүн өгөхгүй бол мэс засал хийж миндалиныг авна.

Шим тэжээл сайтай витаминаар баялаг төрөл бүрийн хоол хэрэглэх нь ангина өвчнөөс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Хүнсний зүйлийн витамин багасдаг өвөл хаврын улиралд эмчээс зөвлөлгөө авч төрөл бүрийн витамин авч уух хэрэгтэй.

Ангинаар өвчлөхгүйн тулд биеийн тамирын дасгал, усан засалыг хослуулан хичээллэх (хүйтэн усаар биеэ арчих, булхах, сэлэх) өдрийн дэглэм нарийн баримтлах, буйл шүдний өвчнийг цаг тухайд нь эмчлүүлэх, хамраараа зөв амьсгалж байх нь чухал.

Д. Отгон

Хариуцлагатай эрхлэгч Н.МӨНХӨӨ

(Х—00025) «АНХДУГААР ТАВАН ЖИЛ» СОНИНЫ ҮЙЛДВЭРТ ХЭВЛЭВ.

Аймгийн АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны хурал

# Нам, засгийн тогтоол шийдвэрийг ширхэгчлэн биелүүлье

6 дугаар сарын 16—ны өдөр Өнжүүл сумын төвд аймгийн Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргааны гишүүдийн өргөтгөсөн хурал болж „БНМАУ—ын Сайд нарын Зөвлөлийн 1967 оны 319 дүгээр тогтоолыг хэрхэн биелүүлж байгаа“ тухай тус сумын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргааны дарга Д. Аюушийн илтгэлийг хэлэлцэв.

Сумын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргаа, улс ардын аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилтуудыг биелүүлэхэд нам, засгийн болон аймгийн Намын Хороо, Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргааны тогтоол шийдвэрийг өөрийн ажилд мөрдлөг болгон ажиллаж ирсэн боловч одоогийн шаардлагад хүрч чадаагүй байна.

Сумын захиргаа удирдах дээд байгууллагын тогтоол шийдвэрийг биелүүлэх зохион байгуулалттай арга хэмжээ авч, биелэлтийг дүгнэх, ялангуяа байнга дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг нэгдэлч олон түмэнд таниулах, хүмүүсийн улс, төр, хууль эрхийн мэдлэгийг дээшлүүлэх талаар зохиосон ажил хангалтгүй байна. Сумын Гүйцэтгэх Захиргаа өнгөрсөн онд төлөвлөгдсөн гол асуудлуудаас бүртгэл тооцоог сайжруулах арга хэмжээ, социалист уралдааныг дүгнэх, худалдаа үйлчилгээний ажил, тэмээ хонины ноос авалт, ашиглалт, хөдөлмөрчдийг киногоор үйлчлэх ажлыг сайжруулах, эмнэлгийн ажилд шинэ санаачлага, тэргүүн туршлага нэвтрүүлэх талаар, олон нийтийн шүүхийн ажлын тухай зэрэг чухал чухал асуудлуудыг хэлэлцээгүй тасалдуулсан байна.

Тус сумын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргаа, харъяа байгууллагуудад тавих төрийн хяналт шалгалтыг сайжруулж гаргасан тогтоол шийдвэртээ гүйцэтгэлийн шалгалт хийх талаар муу анхаарч ажилласнаас 1967—1968 онуудад гаргасан тогтоол шийдвэрийн 50-иас 70 хувьд нь гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийлгүй урсгалд нь тавьж ирсээс албан хариуцлагатны ажил хариуцах хариуцлага суларч энэ нь улс ардын аж ахуйн төлөвлөгөөт зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн байна.

Сумын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргааны дарга байсан Д. Аюуш нь төрийн захиргааны байгууллагын ажлыг жигд сайжруулж аппаратыг хөнгөн шуурхай болгож сум нэгдлийн хөдөлмөр зохион байгуулалт, хүмүүсийн хариуцлагыг өндөржүүлэх талаар тууштай ажил зохиогоогүй ялангуяа мэргэжилтэн хариуцлагатнуудыг ажилд нь эзэн болгох, удирдах байгууллагын шийдвэрийг биелүүлэхэд хариуцлагагүй ажилласан байна.

Сумын захиргааны гишүүн ХБ ангийн дарга Г. Ишжамц, нэгдлийн орлогч дарга н. Төмөрпүрэв, Эвлэлийн Хорооны дарга Б. Шатар нарын зэрэг хариуцлагатай хүмүүс ажил сайжруулахад хүчээ дайчлахын оронд дутагдалтай эвлэрч биеийн амрыг харж суудаг болсон ба сумын Гүйцэтгэх Захиргаанаас өгсөн үүргийг биелүүлэхийн оронд хий маргах нүд хуурч арга цаан өнгөрөөх зэргээр зохисгүй байдал гаргаж байжээ. Зоо-мал эмнэлгийн салбарын эрхлэгчээр ажиллаж байсан малын их эмч н.Дамдинжав нь БНМАУ-ын мал эмнэлгийн албаны дүрмийг биелүүлээгүйгээс 1967 онд 2,8 мянган малыг өвчнөөр хорогдуулж байсан ба урьдчилан сэргийлэх тарилга 70 гаруй литрийг хугацаанд нь тарилгүй өнгөрөөснөөс олон мянган төгрөгийн эмийг хэрэгцээгүй болгожээ.

Тус сумын 3 дугаар бригадын малын бага эмч н. Лодон хариуцсан бригадынхаа малыг эрүүлжүүлэх талаар санаа тавихын оронд сумын удирдах хариуцлагатнуудаас өгсөн үүрэг даалгаврыг удаа дараалан эсэргүүцэж өөрийн дур зоригоор авирлаж байснаас нэгдлийн үйлдвэрлэлийг үлэмж хэмжээгээр хохируулж байсан бөгөөд н. Лодон аймгийн Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргааны гишүүдийн хурал дээр ч дутагдлаа хамгаалж зарчимгүй байдал гаргаж байснаас арга хэмжээ авагдсан билээ.

Сумын Гүйцэтгэх Захиргаа сумынхаа чуулганд депутатуудаа бүрэн хамран оролцуулах талаар муу ажиллаж байсны гадна төрийн захиргааны ажилд депутатуудыг татан оролцуулж гаргасан шийдвэрийг хөдөлмөрчдөд сурталчлан биелүүлэх ажлыг зохион байгуулахад тэдний хүчийг муу ашиглаж байв.

Гүйцэтгэх Захиргааны аппаратын зарим ажилтан сэхээтнүүдийн улс төр, хууль эрхийн мэдлэг дорой,байнга дагаж мөрддөг хууль тогтоомжуудыг мэдэхгүй явдал өргөн хэмжээтэй үзэгдэж байгаа ба сумын захиргаанаас энэ талаар санаачлага тавьж хөдөлмөрчдийн мэдсэн байвал зохих хууль тогтоомжуудыг сурталчлах ажил хангалтгүй зохиогдсоны дээр ажлын цагийг үр бүтээлгүй өнгөрөөх,ажил таслах, нийгмийн тустай хөдөлмөрөөс зайлсхийгчдийг ажилд татан оруулах нийгмийн өмч хөрөнгөнд эзний ёсоор хандахгүй байгаа зэрэг явдлуудтай тэмцэх тэмцлийг урсгалын байдалтай явуулж иржээ.

Сумын захиргаа сууръ бригадыг ажиллах хүчээр шаардлагатай үед нь хангах үндсэнд тухай бүр хөдөлмөрийн үзлэгийг хийдэггүй учраас сумын төвд олон арван хүн ямарч эрхэлсэн ажилгүй зүгээр сууж байхад саалийн тасгуудад саальчаар дутагдах явдал их хэмжээтэй үзэгдэж байна.

Сумын хэмжээгээр хөдөлмөр зохион байгуулалт хангалтгүй сууръ, бригад, албан байгууллагуудын хооронд социалист уралдааны олон хэлбэрийг өрнүүлж ажиллахгүй бригадууд ердийн хөсгийг байнга ашиглах, морь тэмээдийг тэргэнд сургах, малаас гарах ашиг шимийг дээд хэмжээгээр ашиглах зэрэг дотоод нөөц бололцоог дайчлан ажиллахад эдийн засгийн нарийн тоо цоотой ажиллах явдал хангалтгүй байна.

Сумын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргааны дэргэдэх төрийн олон нийтийн үүсгэл санаачлагын байгууллагууд, С. Цэдэв даргатай захиргааны комисс, Д.Самдан даргатай насанд хүрээгүй хүүхдийн хэрэг эрхлэх комисс, н. Төмөрпүрэв даргатай олон нийтийн шүүх, үйлдвэр худалдаа, тээвэр холбооны байнгын комисс н. Нацагдорж даргатай ХАА—н байнгын комисс, н. Банзрагч даргатай соёл гэгээрэл, Эрүүлийг Хамгаалах, хууль дүрмийн байнгын комиссуудын ажил одоогийн шаардлаганд хүрч чадаагүйн дээр өөрсдийн үүрэг зорилгыг биелүүлж, зохих дүрмийнхээ дагуу сум орны төлөвлөгөөт зорилтуудыг биелүүлэхэд тодорхой үр бүтээлтэй ажил зохиосонгүй.

Ийм байдалд сумын захиргаа дүгнэлт хийж төрийн олон нийтийн үүсгэл санаачлагын байгууллагуудын ажлыг дэмжих тэдэнд ажиллах бололцоо олгох, зохих заавар зөвлөлгөөн өгөх, төрийн захиргааны ажилд туслалцуулах ажлыг муу зохион байгуулж ирсний улмаас сумын хэмжээний нийт байгууллагуудад холбогдох дээд газрын тогтоол шийдвэрийг биелүүлэх ажиллагаа жигд биш ялангуяа гуанз, халуун ус, төрөхийн өмнөх байр, цэцэрлэг зэрэг үйлчилгээний газрууд удаа дараалан хаагдаж байсан бөгөөд гуанз, цэцэрлэг,сургуулийн хүүхдийн хоолны амт чанар муу, нэр төрөл цөөн, хүнсний ногоогоор байнга дутагдаж ирсэн байна.

Төрөхийн өмнөх байрны үйлчилгээ, эх нялхасын эрүүл мэндийг хамгаалах талаар хангалтгүй ажиллаж байна.

Тус сумын хэмжээнд хууль зүйг зөрчих явдал үлэмж хэмжээгээр оршиж байна.

Сүүлийн 2 жил дараалан албан журмын ноогдол үүрэг хялгас, хөөвөр, ноолуурын төлөвлөгөөг удаа дараалан таслаж байсан ба одоо ч бодын хөөвөр, ямааны ноолуур бэлтгэн тушаах хугацаа дуусаад байхад бодын хөөвөр 722 кг, ямааны ноолуур 570 кг дутууг гүйцээх талаар санаа зовж хөөцөлдөж байгаа албан хариуцлагатан цөөн байна.

Төрийн Захиргааны зүгээс улс ардын аж ахуйн төлөвлөгөөг тэнцүүлэн хөгжүүлэх асуудал доголдож нэгдлийн үйлдвэрлэлийн гол салбар болох мал аж ахуйн үйлдвэрлэлийг удирдах явдал тун хангалтгүй байна.

Төрөл бүрийн малын хариуллага маллагаанд тавих хяналт шалгалт суларснаас тус сум сүүлийн 3 жил дараалан мал өсгөх улсын төлөвлөгөөг таслаж түүний дотроос нийгмийн малыг 1965 оныхоос 1967 онд 4,7 мянган малаар хорогдуулж мал өсгөх улсын төлөвлөгөөг 7,7 хувиар тасалсан байна.

Түүгээр ч барахгүй 5 дугаар сарын сүүлчээр болсон хүйтэн бороо,цасан шуурганаар малыг хариулага маллагаагүй байлгаснаас олон мянган малыг хорогдуулж энэ онд нийт 14 мянга гаруй малын хорогдлыг гаргаж байгаа нь мал өсгөх улсын төлөвлөгөөнд ноцтой саад учруулж байна.

Тус сумын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргаа аж ахуйг удирдах талаар удирдлагаа төвлөрүүлж ажлын салбар бүрт гүйцэтгэлийн хяналт шалгалтыг орхигдуулан хөдөлмөр зохион байгуулалтыг сулруулж байсан дутагдлууд дээр аймгийн Гүйцэтгэх Захиргааны гишүүдийн хурал тодорхой дүгнэлт өгч,нам засаг удирдах байгууллагын тогтоол шийдвэр, хууль дүрмийг биелүүлэх талаар хариуцлагагүй ажилласан сумын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргааны дарга н. Аюушийг үүрэгт ажлаас нь халсан байна.

Аймгийн Гүйцэтгэх Захиргааны гишүүдийн хурал тус сумын захиргаа, олон нийтийн байгууллага удирдах хүмүүсийн арга барилд оршиж байсан дутагдлыг үндсээр нь илрүүлж цаашдын ажлыг сайжруулах тодорхой заалттай тогтоол гаргалаа.

Улс ардын аж ахуй,соёлыг хөгжүүлэх IV таван жилийн төлөвлөгөөг бүрэн биелүүлэх ялангуяа манай эдийн засгийн чухал салбар мал аж ахуйд учирсан хохиролыг дотоод нөөц бололцоогоо дайчлан ашигласны үндсэн дээр ойрын үед нөхөхөд сумын нийт хөдөлмөрчдийн хүчийг дайчлан зөв зохион байгуулан ажиллах явдал Өнжүүл сумын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргаа, улс, олон нийтийн байгууллагуудын хойшлуулшгүй чухал зорилт болж байна.

Н. Мөнхөө

---

гөөн болгож явуулах нь чухал байна.

Сум хороодын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргаадаас орлогын төлөвлөгөөний биелэлтийн дүнг хурлаараа хэлэлцэж холбогдох арга хэмжээнүүдийг цаг тухайд нь авах хэрэгтэй.

Аймгийн ХАА-н нэгдлүүдийн ашиг орлогын татварыг тооцохдоо нэгдлийн зөвлөлийн санхүүгээс зах зээлд борлуулсан буюу гишүүдэд борлуулсаныг нарийн зааглаж гишүүдэд борлуулсанығаа дотор нь зах зээлийн үнээр буюу тогтоосон үнээр гэж ялгах нь ашиг орлогын татварыг зөв тогтоохын үндэс нь болно гэдгийг анхаарах хэрэгтэй.

Орон нутгийн орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд Ардын Депутатуудын Хурлын төсөв төлөвлөгөөний байнгын комиссууд болон депутатууд, идэвхтнүүдийн хүчийг дайчлан оролцуулж сайн ажилласан хүмүүсийг оруулсан орлогын 10 хувиар шагнах журмыг өргөн хэрэглэвэл зохино.

Аймгийн Санхүүгийн хэлтсийн дарга

Д. Сундуй